

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ЭМЭГТЭЙ АЛБА ХААГЧДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ, ТҮҮНИЙ ОНЦЛОГ

DIRECTIONS AND FEATURES OF THE WORK OF FEMALE POLICE OFFICERS

В.Номинчулуун

*ДХИС-ийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Аюулгүй байдал судлалын төвийн
эрдэм шинжилгээний ахлах ажилтан-багш, цагдаагийн хошууч*

Товч агуулга: Төрийн бүх шатны байгууллагууд бодлого, үйл ажиллагаагаа жендэрийн мэдрэмжтэй төлөвлөж, хэрэгжүүлэх нь улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, гэр бүлийн харилцааны бүхий л хүрээнд жендэрийн эрх тэгш байдлыг нэвтрүүлж, хэвшүүлэх нөхцөл бололцоог бүрдүүлэх ач холбогдол болон нийгмийн шаардлагыг үндэслэн, төрийн албан хаагчдын жендэрийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, өдөр тутмын үйл ажиллагаагаа жендэрийн мэдрэмжтэй төлөвлөх, хэрэгжүүлэх, удирдлагаар хангах, судалгаа хийх, нөөц хуваарилах, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ур чадварт суралцах эрэлт, хэрэгцээ үүссээр байна.

Түүнчлэн цагдаагийн байгууллагын эмэгтэй алба хаагчдын үйл ажиллагааны чиглэл, онцлогийг тодорхойлон эмэгтэй алба хаагчдад цагдаагийн албаны ямар ажил илүү тохиромжтой эсэх мөн үүрэг гүйцэтгэхэд учрах хүндрэл бэрхшээл тулгамдаж буй асуудлыг нээн илрүүлж оновчтой арга замыг тодорхойлоход судалгааны ажлын зорилго оршино.

Abstract: It is important for all levels of government to plan and implement their policies and activities with gender sensitivity, based on the importance of creating conditions for the introduction and normalization of gender equality in all spheres of political, economic, social, cultural, and family relations, and on the demands of society there is a growing demand and need for staff to increase their knowledge and understanding of gender, and to learn skills in gender-sensitive planning, implementation, management, research, resource allocation, monitoring, and evaluation.

In addition, the purpose of the research is to identify the areas and characteristics of female police officers' activities, determine which police jobs are more suitable for female officers, and identify the problems and obstacles they face in performing their duties, and determine the best ways to do so.

Түлхүүр үгс: Эмэгтэй алба хаагч, үйл ажиллагааны чиглэл, ажлын онцлог, хүндрэл, бэрхшээл.

Keywords: Female officers, areas of activity, job characteristics, difficulties and challenges.

Аливаа байгууллагад мэдлэгтэй, чадвартай хүн хүсэмжит боловсон хүчин байдаг цаг аажмаар өөрчлөгдөж, мэргэшсэн бөгөөд зөв хандлагатай хүн хамгийн чухал боловсон хүчинд тооцогдох болжээ.

Цагдаагийн байгууллагад ерөнхий мэдлэгтэй хүнээс илүү голлох нэг чиглэлд түлхүү мэргэшсэн, дээр нь хандлага сайтай алба хаагч үгүйлэгдэж байна. Мэдээж хэрэг, энэ чадварыг олон жилийн туршлагаар эзэмших боломжтой хэдий ч, сургалтаар олж авах нэг гарц бий гэж үзэж байна. Тус судалгаанд цагдаагийн байгууллагад ажиллаж байгаа 825 эмэгтэй алба хаагч хамрагдсан болно.

Зураг 1.



тохиолдлууд багагүй бүртгэгдэх болсон. Энэ тохиолдолд хэлний бэрхшээлээс болж хохирогч талууд цагдаагийн байгууллагын алба хаагчидтай шууд харилцаж, эрх, ашгаа хамгаалуулах боломжгүй байна.

Цагдаагийн байгууллагын удирдлагын зүгээс алба хаагчдынхаа гадаад хэлний мэдлэгийг сайжруулах тал дээр сүүлийн жилд анхаарах болсон хэдий ч, сонгогдсон алба хаагчийг тогтмол байдлаар давтан сургаж, англи хэлний мэргэшсэн түвшинд хүргэх зорилго хараахан биелэхгүй байна. Тиймээс энэ чиглэлээр эмэгтэй алба хаагчдыг түлхүү хамруулж, хэлний өндөр мэдлэгтэй алба хаагч бэлтгэн, жуулчдын аюулгүй байдлыг хангаж, наад захын мэдээллээр ханган, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах нь олон улсын жишигт нийцэх бөгөөд цагдаагийн байгууллагын эмэгтэй алба хаагчдын албанд ажиллахад тохиромжтой нэг чиглэл болох давуу талтай.

Энэ мэтээр Цагдаагийн байгууллагад эмэгтэй алба хаагчид ажиллахад илүү тохиромжтой алба, нэгжийн талаар судалж, тухайн чиглэлд нарийвчилсан мэдлэг, боловсрол олгох замаар алба хаагчийг мэргэшүүлэх шаардлагатай.

ХЭҮК-оос 2014 онд ЖЭТБХТХ-ийн 11 дүгээр зүйлд заасан хөдөлмөрийн харилцаан дахь жендэрийн эрх тэгш байдлын хэрэгжилтийн талаар судалгаа, дүн шинжилгээ хийжээ. Судалгаагаар хөдөлмөр эрхлэлт болон хөдөлмөрийн харилцаанд жендэрээр ялгаварлан гадуурхах, эмэгтэй, эрэгтэй ажилтанд ажил болон гэр бүлийн үүргээ хослуулах, ижил ажилд адил цалин, нэмэгдэл хөлс тогтоох, ажлын байран дахь бэлгийн дарамтаас ангид орчин бүрдүүлэх, урьдчилан сэргийлэх нөхцөл байдал, хуулийн хэрэгжилтийг төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд хэрхэн хангаж байгаад анхаарал хандуулсан юм. Комисс судалгаандаа Улаанбаатар хот, Орхон аймаг, Өмнөговь аймгийн Цогтцэций суманд үйл ажиллагаа явуулж буй төрийн захиргааны болон хувийн хэвшлийн 24 байгууллагын 514 хүнийг хамруулсан бөгөөд эдгээрээс төрийн тусгай алба хаагч эмэгтэй 44.2 хувь, эрэгтэй 55.7 хувийг эзэлжээ.

Судалгаанд хамрагдагсад хүйсийн ялгаварлан гадуурхалт оршсоор байгааг хүлээн зөвшөөрч, мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн зэрэг ахиулах боломж эрэгтэйчүүдэд илүү байдаг гэж үзсэн байна (комисс Х. э., Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 13 дахь илтгэл, 2014).

Зураг 2. Мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн зэргээ ахиулах боломж (салбараар, хүйсээр)

№	Салбараар	Эсрэг хүйсийн хүнтэй харьцуулахад илүү боломжтой	Эсрэг хүйсийн хүнтэй харьцуулахад бага боломжтой
1	Эдийн засгийн салбар		Эмэгтэй ажилтан
2	Боловсрол		Эрэгтэй ажилтан
3	Эрүүл мэнд	Эрэгтэй ажилтан	
4	Төрийн захиргаа	Эрэгтэй ажилтан	Эмэгтэй ажилтан
5	Төрийн тусгай	Эрэгтэй ажилтан	Эмэгтэй ажилтан
6	Уул уурхай		Эмэгтэй ажилтан
7	Банк		Эмэгтэй ажилтан
8	Үүрэн холбоо	Эрэгтэй ажилтан	Эмэгтэй ажилтан
9	Худалдаа		Эмэгтэй ажилтан

Эсрэг хүйсийн хүнтэй харьцуулахад “Мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн зэргээ ахиулах илүү боломжтой” гэж хариулсан ажилтнууд нь бүгд эрэгтэй байсан бол “Ийм боломж бага” гэж эмэгтэйчүүдийн олонх нь хариулсан ажээ. Тэгэхээр төрийн албанд эмэгтэй алба хаагч мэргэжил дээшлүүлэх, цаашлаад албан тушаал ахиж дэвших боломж эрэгтэй алба хаагчидтай харьцуулахад илүү хомс байгааг судалгааны үр дүн харуулж байна.

“Цагдаагийн байгууллагын мөрдөгчдийн хувьд цагдаагийн алба хаагчийн нийтлэг үүрэг, орон тоо, ажлын ачаалал, нэг мөрдөгчид оногдох хэрэг бүртгэлтийн болон эрүүгийн хэрэг, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл шалгах, тухайн мөрдөгчийн мэдлэг, ур чадвар, мөрдөн шалгах ажиллагааны туршлага зэрэг олон хүчин зүйлээс хамаарч зарим үед хэрэг шалгах хугацаа удаашрах тохиолдол гарч байна. Тиймээс цагдаагийн байгууллагын мөрдөгчдийн ажлын зохион байгуулалтыг оновчтой болгох, мөрдөн шалгах ажиллагаа явуулах эдийн засгийн баталгааг бүрдүүлэх, мэргэжлийн чадавхыг нэмэгдүүлэх талаар бодлогын шинжтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх нь хүн хэргээ аль болох богино хугацаанд шүүхээр шийдвэрлүүлэх эрхийг хангах үндэс болно” (комисс Х. э., Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, 2023) гэж ХЭҮК-оос үзсэн бөгөөд мөрдөн шалгах ажиллагаанд тулгарсан хүндрэл, бэрхшээл нэмэлт хугацаа шаардаж болох ч дотоод зохион байгуулалт, орон тооны хомсдол, төсөв хөрөнгийн улмаас хэргийг шийдвэрлэх ажиллагаа удаашрах ёсгүй бөгөөд ийм нөхцөл байдлыг төр шийдвэрлэх үүрэгтэй талаар дурджээ. Эдгээр нь дан ганц мөрдөн шалгах чиглэлд үүсэж байгаа бэрхшээл болохыг тодотгох нь зүйтэй юм.

Цагдаагийн байгууллагын эмэгтэй алба хаагчид ч мөн адил мөрдөн шалгах чиглэлийн дагнасан үүрэг гүйцэтгэдэг тохиолдол практикт цөөнгүй. Тэгвэл эмэгтэй алба хаагчдын хувийн онцлогт үндэслэн, ямар гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах боломжоор хангах нь илүү үр дүнтэй байдаг талаар дагнасан судалгаа, түүнд үндэслэн гаргасан санал, зөвлөмжтэй хараахан таарсангүй.

Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогчдын давамгайлах хэсэг нь эм хүйсийн хүн байдаг онцлогтой. Энэ гэмт хэрэгт хохирсон хүний сэтгэл санаа тогтворгүй бөгөөд бусдаас айж эмээсэн, нэр хүндээ алдахаас сэрэмжилсэн, нэлээд хаалттай байдаг учир мөрдөн шалгах ажиллагааг үр дүнтэй явуулахад саад учруулдаг. Энэ тохиолдолд цагдаагийн байгууллагын зүгээс мэргэшсэн эмэгтэй алба хаагчдыг бэлтгэн, зөвхөн хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах боломжийг бүрдүүлэх нь энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд дөхөмтэй алхам болно гэж үзэж байна.

Аливаа зүйл хоёр талтай байдгийн адил амар хялбар аргаар ашиг олох гэсэн шунахайн сэдлээр бусдад хүчиндүүлсэн мэт хуурамч өргөдөл, гомдол гаргаж, гэм буруугүй хүнийг гэмт хэрэг үйлдсэн мэтээр хохироодог тохиолдол цөөнгүй үзэгдэх явдал эдийн засгийн хямралтай нөхцөлдөж, нийгэмд элбэг гарах болсон өнөө үед бусдын бэлгийн эрх

чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгах тусгайлсан чиг үүрэг бүхий эмэгтэй алба хаагчдыг бэлтгэж, мэргэшүүлэх зайлшгүй шаардлага үүсжээ. Өөрөөр хэлбэл, энэ төрлийн гэмт хэргийг шалгахдаа нэг талыг хэт барихаас зайлсхийж, болоод өнгөрсөн нөхцөл байдлыг тал бүрээс нь тогтоож, хохирогч болон холбогдогчийн сэтгэл зүй, сэдэлт, зорилгыг заавал тогтооно гэсэн үг. Уг ажлыг эмэгтэй алба хаагч илүү чадварлагаар явуулах боломжтой болох нь практикаас ажиглагддаг.

Тэгэхээр Цагдаагийн байгууллагын эмэгтэй алба хаагчдыг илүү үр дүнтэй гүйцэтгэх боломжтой албанд ажиллуулах нь гэмт хэрэгтэй тэмцэх, бусдын зөрчигдсөн эрхийг сэргээх, үйлдээгүй гэмт хэрэгт ял эдлэх зэрэг олон асуудлыг оновчтой шийдвэрлэх арга зам болох юм.

Хууль сахиулах чиг үүрэг бүхий байгууллагын албан хаагчид, хуульд заасан үндэслэл, журмын дагуу нийтийн хэв журмыг хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажиллагаа явуулдгийн хувьд тодорхой эрх эдэлж, үүрэг хүлээдэг. Тэд өдөр тутмын үүрэг гүйцэтгэхдээ нийгмийн ёс суртахууны ноцтой зөрчил гаргасан болон гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдтэй шууд харилцаанд орж, хууль зөрчих явдлыг таслан зогсоох ажлынхаа явцад, зөрчил гаргасан болон гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийн зүгээс гаргах эсэргүүцэлтэй нүүр тулж, хэл амаар доромжлуулах, халдлагад өртөх, гэмтэж, бэртэх асуудал түгээмэл тохиолдохоос гадна, бүр цаашлаад амь насаа алдах явдал гардаг нь нийгмийн аюулын шинжийг тодорхойлж байна.

Энэ чиглэлийн албыг эмэгтэй алба хаагчдаар дагнан гүйцэтгүүлэх нь тийм ч оновчтой бус. Учир нь эмэгтэй хүн эрэгтэй хүнтэй харьцуулахад байгалиасаа хүч чадал султай тул аливаа хүч хэрэглэсэн үйлдлийн эсрэг үзүүлэх нөлөө дутмаг. Ийм ч учраас нийгмийн хэв журмыг зөрчигчдийн хууль бус үйлдлийг таслан зогсоохын оронд өөрөө хохирогч болох эрсдэл өндөр байдаг. Судалгаанд оролцогчдоос “Та албан үүргээ гүйцэтгэж байхдаа эрүүл мэндээрээ хохирч байсан уу?” гэх асуултад 620 (75.2%) алба хаагч “Үгүй”, 205 (24.8%) алба хаагч “Тийм” гэж хариулсан нь үүрэг гүйцэтгэх үедээ хохирох эрсдэлийг харуулж байна.

Зураг 3.



Хуульд заасан албаны тодорхой үүргээ үр дүнтэй гүйцэтгэхэд биеийн хүчний механик ажиллагаа нөлөөлөхөөс гадна эрх зүйн орчин төгөлдөржсөн байх нь нэн чухал. Учир нь цагдаагийн байгууллагын алба хаагчид өдөр тутамдаа иргэдийн эрхэд шууд хязгаарлалт тогтоох давуу эрх эдэлдэг. Мэдээж хэрэг, давуу эрх эдлэхийн хажуугаар, түүнд таарсан өндөр үүрэг хүлээдэг нь үнэн. Нийгэмд эмх журам тогтоох, гэмт хэрэг үйлдсэн этгээдэд шударга ял оноох, цаашид гэмт

хэрэг, зөрчлийн гаралтыг багасгах, царцаах чиглэлийн үйл ажиллагаа нь сөрөг уур амьсгал, догшин авир, хандлагатай байнга нүүр тулахад хүргэдэг. Жишээ нь, хулгайлах гэмт хэрэг үйлдэгдсэн байлаа гэхэд тэр хэрэг, учралын мөн чанарыг олж тогтоох гэж хэн нэгэн хүнийг холбогдуулан шалгах хэрэгтэй болно. Нэг нь эд зүйлээ хурдхан олуулах гэж бухимдаж байгаа бол нөгөө нь хэрэг үйлдсэн хэрнээ нуун дарагдуулах гэж оролдох гэх мэтчилэн янз бүрийн ааш, аяг гаргана. Энэ бүхнээс үзвэл, ихэвчлэн сөрөг сэтгэл хөдлөлтэй хүмүүстэй харьцдаг нь цагдаагийн алба хаагчийн ажлын онцлог юм. Хохирогчийн зүгээс хамгаалуулах гэсэн ашиг сонирхол, холбогдогчийн хариуцлагаас зайлсхийх гэсэн ашиг сонирхолтой харшилдаж байдаг нь жам ёсны зүйл бөгөөд энэ хоорондын харилцааг хууль ёсонд

нийцүүлэн, шударгаар зохицуулахад чиглэсэн үйл ажиллагаа нь алба хаагчдыг хохироход хүргэх явдал цөөнгүй.

Зураг 4.




Судалгаанд оролцогчдод тавьсан “Албан үүргээ гүйцэтгэх эрх зүйн орчин ямар байна вэ?” гэх асуултад 115 (13.9%) нь “Эрх зүйн орчин тун хангалтгүй байдаг”, 198 (24%) нь “Эмэгтэй алба хаагчдад үзүүлэх хөнгөлөлт, урамшуулал дутагдалтай”, 431 (52.2%) нь “Цагдаагийн эмэгтэй алба хаагчдаар зогсохгүй, бүх алба хаагчдыг хамгаалах тогтолцоо тун дутмаг” гэсэн бол зөвхөн 81 (9.8%) алба хаагч “Албан үүргээ гүйцэтгэх эрх зүйн орчин хангалттай сайн” гэжээ. Судалгаанд оролцогчдын дийлэнх хувь нь алба хаагчдыг хамгаалах тогтолцоо дутмаг байгааг тодотгосон нь цагдаагийн албанд

ажиллах явцад хууль ёсны үйл ажиллагааны үр дүнд үүссэн эрх зүйн үр дагаврын төлөө алба хаагчдыг хамгаалахын оронд буруутгадаг тогтолцоо давамгайлсан бөгөөд удирдлагын зүгээс үүнтэй нэгэнт эвлэрсэн болохыг тодорхой хэмжээгээр харуулж байна.

Магадгүй цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны чиглэлээс хамаарч, эмэгтэй алба хаагчдыг албан тушаалд томилохдоо тэдний онцлогийг харгалзах нь зүйтэй байж болох юм.

Судалгаанд оролцогчдод тавьсан “Цагдаагийн албанд хүйсийн онцлогийг харгалзан албан тушаалд томилдог тогтолцоог дэмжих үү? гэсэн асуултад оролцогчдын 457 (57.7%) нь “Үгүй”, 349 (42.3%) нь “Тийм” гэж хариулсан байна. Мөн “Танай удирдлагын зүгээс таны нас, биеийн онцлогт тохирсон ажил, үүрэг гүйцэтгүүлэх тал дээр анхаарч байна уу?” гэсэн асуултад дийлэнх нь болох 326 (39.7%) алба хаагч “Цагдаагийн албанд хүйсийн онцлогоор ялгаж ажил олгох тогтолцоо байдаггүй” гэсэн хариулт сонгожээ.

Зураг 5.



Зураг 6.



Мэдээж хэрэг, албан тушаалд томилохдоо бусдыг хүйсийн онцлогоор ялгах нь Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжоос гадна Монгол Улсын нэгдэн орсон гэрээ, конвенцыг зөрчинө. Харин албан тушаалд томилохдоо алба хаагчдын хүсэл, сонирхол дээр үндэслэж, хүйсийн онцлогийг харгалзах нь ажлыг үр дүнтэй, тогтвортой, чанартай явуулах нэг арга болох боломжтой.

Зураг 7.



Судалгаанд оролцогчдоос “Эмэгтэй алба хаагчдад цагдаагийн албаны ямар ажил илүү тохиромжтой байдаг вэ? (1-с дээш хариулт сонгож болно)” гэх асуултад 123 (14.9%) хувь нь “Гэмт хэрэгтэй тэмцэх”, 97 (11.8%) нь “Хэв журам сахиулах”, 580 (70.3%) нь “Захиргааны чиглэл”, 28 (3.4%) нь “Замын хөдөлгөөн зохицуулах”, 535 (64.8%) нь “Хэвлэл мэдээлэл, урьдчилан сэргийлэх”, 386 (46.8%) нь “Мэдээлэл, шуурхай удирдлага” гэж санал бодлоо илэрхийлжээ.

Нийт судалгаанд оролцогчдын дийлэнх нь захиргаа болон хэвлэл мэдээлэл, урьдчилан сэргийлэх чиглэлээр эмэгтэй алба хаагч үүрэг гүйцэтгэх нь зохимжтой гэж үзсэн нь санамсаргүй зүйл биш юм. Асуулгад оролцсон эмэгтэй алба хаагчид нь яг одоогийн байдлаар цагдаагийн байгууллагын бүх чиглэлд үүрэг гүйцэтгэж, эерэг бөгөөд сөрөг талыг өөрийн биеэр мэдэрч байгаагийн хувьд ажил, албаны аль төрөлд эмэгтэйчүүдийн оролцоо илүү хэрэгцээтэй болоод тохиромжтой болохыг бодитой тодорхойлж чадах үндсэн субъект мөн билээ.

Зураг 8. Цагдаагийн байгууллагын эмэгтэй алба хаагчдын ажлын чиглэлийг судалгаанд оролцогчдын саналтай харьцуулсан байдал.

№	Одоо ажиллаж байгаа ЦБ-ын эмэгтэй алба хаагчдын ажлын чиглэл							
1	Хэмжих нэгж	Захиргаа	Гэмт хэрэгтэй тэмцэх	Мэдээлэл, шуурхай удирдлага	Хэв журам хамгаалах	Замын хөдөлгөөн зохицуулах	Хэвлэл мэдээлэл, урьдчилан сэргийлэх	Бусад
	Тоогоор	504	117	150	181	20	81	217
	Хувиар	39.6	9.2	11.8	14.2	1.5	6.3	13.3
Судалгаанд оролцогч ЦБ-ын эмэгтэй алба хаагчдын санал								
2	Тоогоор	580	123	386	97	28	535	-
	Хувиар	70.3	14.9	46.8	11.8	3.4	64.8	-


Цагдаагийн байгууллагад одоо ажиллаж байгаа нийт эмэгтэй алба хаагчдын ажлын чиглэлийг судалгаанд оролцогчдын саналтай харьцуулахад, дийлэнх (580 – 70.3%)-ийн сонгосон захиргааны чиглэлийн үйл ажиллагаа явуулах нь тохиромжтой байгаа гэх санал одоо захиргааны чиглэлээр ажиллаж байгаа эмэгтэй алба хаагчдын (504 – 39.6%) хувьтай, гэмт хэрэгтэй тэмцэх болон замын хөдөлгөөн зохицуулах чиглэлээр үүрэг гүйцэтгэж байгаа эмэгтэй алба хаагчдын хувь тус тус ерөнхийдөө дүйцэж байна. Харин хэв журам хамгаалах чиглэлээр үүрэг гүйцэтгэж байгаа эмэгтэй алба хаагчдын тоо (181 – 14.2%) хүсэмжит (97 – 11.8%) хувиас хавьгүй их байна. Тэгвэл хэвлэл мэдээлэл, урьдчилан сэргийлэх чиглэлээр үүрэг гүйцэтгэж байгаа эмэгтэй алба хаагчдын хувь (81 – 6.3%) нь хүсэмжит (535 – 64.8%) хувиас хавьгүй бага байна. Мөн мэдээлэл, шуурхай удирдлагын чиглэлээр үүрэг гүйцэтгэж байгаа эмэгтэй алба хаагчдын тоо (150 – 11.8%) нь хүсэмжит (386 – 46.8%) хувиас нэлээд бага байгаа нь анхаарал татаж байна.

Судалгааны үр дүнгээс үзэхэд, хэв журам хамгаалах болон бусад чиглэлээр үүрэг гүйцэтгэж байгаа эмэгтэй алба хаагчдыг мэдээлэл, шуурхай удирдлага ба хэвлэл мэдээлэл, урьдчилан сэргийлэх чиглэлээр үүрэг гүйцэтгэх боломжийг хангах хэрэгцээтэй мэт харагдаж байна. Мэдээж хэрэг, алба хаагчдыг шилжүүлэн томилох асуудал зөвхөн өөрсдийнх нь хүсэл зоригийн үндсэн дээр явагдах ёстой. Уг зураглалын дагуу Цагдаагийн

байгууллагын эмэгтэй алба хаагчдыг өөр албанд шилжүүлэн томилох эсэх асуудлын шаардлага доорх судалгаанд үндэслэгдэж байна.

Судалгаанд оролцогчдод тавьсан “Гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр үүрэг гүйцэтгэхэд танд ямар асуудал тулгарч байна вэ?” гэх асуултад, 150 (18.8%) алба хаагч “Мөрдөн шалгах ажиллагаа явуулах нь эмэгтэй алба хаагчдад хүнд байдаг”, 189 (23.7%) нь “Мөрдөн шалгах ажиллагаа явуулахад эмэгтэй алба хаагчдад хүндрэлтэй зүйл байдаггүй” гэсэн бол 460 (57.6%) алба хаагч “Би өөрөө энэ төрлийн ажил хийдэггүй. Гэхдээ эмэгтэй алба хаагчдад ийм ажил туйлын тохиромжгүй гэж үзэж байна” гэсэн хариултыг сонгожээ. Судалгаанд оролцогчдод тавьсан “Хэв журам сахиулах чиглэлээр үүрэг гүйцэтгэхэд хүндрэл учирч байна уу?” гэсэн асуултад 173 (21.5%) нь “Эмэгтэй алба хаагчдын тавьсан шаардлагыг биелүүлэхгүй байх явдал их байдаг”, 153 (19%) нь “Эмэгтэй алба хаагчдын бие махбодод халдах явдал түгээмэл байдаг учир энэ төрлийн ажил эмэгтэй алба хаагчдад зохихгүй”, 373 (46.4%) алба хаагч “Миний харж (сонсож) байгаагаар эмэгтэй алба хаагчдаар хэв журмын үүрэг гүйцэтгүүлэх нь төдийлөн оновчтой, үр дүнтэй байдаггүй” гэж хариулсан бол зөвхөн 105 (13.1%) нь “Хэв журам сахиулахад эмэгтэй алба хаагчдад хүндрэл учирдаггүй” гэжээ.

Зураг 9.



Цагдаагийн байгууллагын эмэгтэй алба хаагчид гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр үүрэг гүйцэтгэхэд хүндрэлтэй байгааг судалгаанд оролцогчдын дийлэнх хувь нь үзсэнээс гадна хэв журам хамгаалах чиглэлээр үүрэг гүйцэтгэх нь төдийлөн оновчтой бус байгаа хэмээн үзсэн санал бодлыг үндэслэн эдгээр албанд ажиллаж байгаа эмэгтэй алба хаагчдыг мэдээлэл, шуурхай удирдлага ба хэвлэл мэдээлэл, урьдчилан сэргийлэх чиглэлээр, эсхүл бусад нарийн мэргэжлийн чиглэлээр (мэргэжил, мэргэшлийг харгалзан) үүрэг гүйцэтгүүлэх нь зүйтэй хэмээн үзэж байна.

Гэмт хэрэгтэй тэмцэх болон хэв журам сахиулах чиг үүрэг нь алба хаагчаас хувийн зохион байгуулалт шаардахаас гадна тэсвэр тэвчээрийг их шалгадаг ажил мөн билээ. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилт нь гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоон шударгаар ял оногдуулах, гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байх, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээхэд оршино (УИХ, 2017). Энэ зорилтыг хэрэгжүүлэх ажиллагаа тийм ч амар зүйл биш болох нь ойлгомжтойб

Зураг 10.




Тэгвэл нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажиллагаа нь дутахгүй олон төрлийн үйл ажиллагаа явуулдаг. Заримыг цухас дурдахад, зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах, бүртгэх, хуулиар харьяалуулсан зөрчлийг шалгаж шийдвэрлэх, байгууллага, алба хаагчийг мэдээллээр хангах; гудамж, талбай болон нийтийн эзэмшлийн бусад газарт эргүүл хийх, байнгын болон түр ажиллагаатай хянаж-нэвтрүүлэх цэг

ажиллуулах дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг, бусад арга, техник хэрэгсэл ашиглан хяналт тавих; замын хөдөлгөөний аюулгүй байдлын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах; насанд хүрээгүй хүнийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах; гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах; гэрээт харуулын болон хувийн хамгаалалтын үйл ажиллагаанд хяналт тавих, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах; хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх явцад илэрсэн гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг арилгуулах, тэдгээрийг гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор иргэн, хуулийн этгээдэд шаардлага, сэрэмжлүүлэг өгөх, биелэлтийг нь хангуулах; олон нийтийн цагдааг мэргэжил, арга зүйгээр хангах (УИХ, Цагдаагийн албаны тухай хууль. 11 дүгээр зүйл., 2017) зэрэг хамаарахаас гадна олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлийн үйл ажиллагааг давхар гүйцэтгэдэг.


Нэг цагдаагийн газар, хэлтэст ажиллаж буй алба хаагчдын 60-65 хувийг нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэгтэй, эргүүл, харуулын цагдаа, хэсгийн байцаагч, хэсгийн төлөөлөгч, хорооны цагдаа, жолооч цагдаа, машинт эргүүлийн офицер, замын хөдөлгөөн зохицуулагч цагдаа зэрэг албан тушаал эзэлж байгаа бөгөөд, дурдсан алба хаагчдын ажлын чиг үүрэг, онцлог нь гудамж, талбай, зам харгуй, албаны тээврийн хэрэгсэл дотор албан үүрэг гүйцэтгэдгээс үүдэн, эмэгтэй алба хаагч ажиллахад төдийлөн таатай албан тушаал болох нь эргэлзээтэй. Замын хөдөлгөөн зохицуулах үүрэг нь хэв журам сахиулах ажиллагааны нэг хэлбэр болохын хувьд нийтийн хэв журмыг хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлийн үйл ажиллагааны төрөлд хамаарна.

Зураг 11.



төхиромжгүй болохыг бэлхнээ харуулжээ.

Зураг 12.




Судалгаанд оролцогчдод тавьсан “Замын хөдөлгөөн зохицуулах чиглэлээр үүрэг гүйцэтгэхэд хүндрэл учирч байна уу?” гэсэн асуултад дийлэнх нь болох 549 (68.2%) алба хаагч “Би өөрөө энэ төрлийн ажил хийдэггүй. Гэхдээ эмэгтэй алба хаагчдад ийм ажил туйлын тохиромжгүй гэж үзэж байна” гэж, 208 (25.8%) нь “Замын хөдөлгөөн зохицуулах ажлын орчин, нөхцөл хүнд байдаг учир эмэгтэй алба хаагч ажиллахад тохиромжгүй” хэмээн үзэл бодлоо илэрхийлснээс үзэхэд, замын хөдөлгөөн зохицуулах чиглэлээр үүрэг гүйцэтгэх нь эмэгтэй алба хаагчдад тун

Судалгаанд оролцогчдод тавьсан “Захиргааны чиглэлийн үүрэг гүйцэтгэхэд танд хүндрэлтэй зүйл байдаг уу” гэх асуултад 394 (48.8%) нь “Захиргааны албанд ажиллах нь эмэгтэй хүнд яг тохирсон” гэж үзсэн бол 350 (43.4%) нь “Би өөрөө ийм төрлийн ажил хийдэггүй. Гэхдээ эмэгтэй алба хаагчдад ийм ажил хамгийн тохиромжтой гэж үзэж байна” хэмээн үзэл бодлоо илэрхийлсэн.

Зураг 13.


Хэвлэл мэдээлэл, урьдчилан сэргийлэх чиглэлээр үүрэг гүйцэтгэх нь танд тохиромжтой байна уу?



38 (4.7%) алба хаагч л “Эмэгтэй алба хаагчдад тохиромжгүй” гэжээ.

Зураг 14.

Мэдээлэл, шуурхай удирдлагын чиглэлийн албанд үүрэг гүйцэтгэх нь танд тохиромжтой байна уу?



Эмэгтэй алба хаагчдаас “Мэдээлэл, шуурхай удирдлагын чиглэлийн албанд үүрэг гүйцэтгэх нь танд тохиромжтой байна уу?” гэх асуултад 244 (30.4%) нь “Мэдээлэл, шуурхай удирдлагын ажил надад тохиромжтой байдаг” гэсэн бол 500 (62.3%) алба хаагч “Би өөрөө ийм төрлийн ажил хийдэггүй. Гэхдээ эмэгтэй алба хаагчдад ийм ажил хамгийн тохиромжтой гэж үзэж байна” хэмээн үзэл бодлоо илэрхийлсэн байхад зөвхөн 58 (7.2%) нь “Эмэгтэй алба хаагчдад тохиромжгүй” гэж үзжээ.

Цагдаагийн байгууллагын эмэгтэй алба хаагчид ямар ажил, үүрэг гүйцэтгэхэд илүү дөхөм бөгөөд үр дүнтэй болох, ямар ажил нь тэдний хүйсийн онцлогт тохирох эсэх талаар гаргасан судалгааны үр дүнд үндэслэн одоо ажиллаж байгаа Цагдаагийн байгууллагын эмэгтэй алба хаагчдыг дотооддоо шинээр зохион байгуулж, шинэ албан тушаалын гүйцэтгэлийн үр дүнг өмнөхийн буюу хуучин албан тушаалд ажиллаж байсан цаг хугацааны үр дүнтэй харьцуулсан судалгаа хийх замаар үр дүн, цаашдын чиг хандлагыг тодорхойлох нь үр ашигтай ажил болох боломжтой гэж үзэж байна.

Дүгнэлт

Төрийн албанд эмэгтэй алба хаагч мэргэжил дээшлүүлэх, цаашлаад албан тушаал ахиж дэвших боломж эрэгтэй алба хаагчидтай харьцуулахад илүү хомс байгааг судалгааны үр дүн харуулж байна.

Хууль сахиулах чиг үүрэг бүхий байгууллагын албан хаагчид, хуульд заасан үндэслэл, журмын дагуу нийтийн хэв журмыг хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажиллагаа явуулдгийн хувьд тодорхой эрх эдэлж, үүрэг хүлээдэг. Тэд өдөр тутмын үүрэг гүйцэтгэхдээ нийгмийн ёс суртахууны ноцтой зөрчил гаргасан болон гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдтэй шууд харилцаанд орж, хууль зөрчих явдлыг таслан зогсоох ажлынхаа явцад, зөрчил гаргасан болон гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийн зүгээс гаргах эсэргүүцэлтэй нүүр тулж, хэл амаар доромжлуулах, халдлагад өртөх, гэмтэж, бэртэх асуудал түгээмэл тохиолдохоос гадна, бүр цаашлаад амь насаа алдах явдал гардаг нь нийгмийн аюулын шинжийг тодорхойлж байна.

Иймд цагдаагийн байгууллагын эмэгтэй алба хаагчдыг илүү үр дүнтэй гүйцэтгэх боломжтой албанд ажиллуулах нь гэмт хэрэгтэй тэмцэх, бусдын зөрчигдсөн эрхийг сэргээх, үйлдээгүй гэмт хэрэгт ял эдлэх зэрэг олон асуудлыг оновчтой шийдвэрлэх арга зам болох юм.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны чиглэлээс хамаарч, эмэгтэй алба хаагчдыг албан тушаалд томилохдоо тэдний онцлогийг харгалзах нь зүйтэй.

Судалгааны үр дүнгээс үзэхэд, хэв журам хамгаалах болон бусад чиглэлээр үүрэг гүйцэтгэж байгаа эмэгтэй алба хаагчдыг мэдээлэл, шуурхай удирдлага ба хэвлэл мэдээлэл, урьдчилан сэргийлэх чиглэлээр үүрэг гүйцэтгэх боломжийг хангах хэрэгцээтэй мэт харагдаж байна. Цагдаагийн байгууллагын эмэгтэй алба хаагчид гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр үүрэг гүйцэтгэхэд хүндрэлтэй байгааг судалгаанд оролцогчдын дийлэнх хувь нь үзсэнээс гадна хэв журам хамгаалах чиглэлээр үүрэг гүйцэтгэх нь төдийлөн оновчтой бус байгаа хэмээн үзсэн санал бодлыг үндэслэн эдгээр албанд ажиллаж байгаа эмэгтэй алба хаагчдыг мэдээлэл, шуурхай удирдлага ба хэвлэл мэдээлэл, урьдчилан сэргийлэх чиглэлээр, эсхүл бусад нарийн мэргэжлийн чиглэлээр (мэргэжил, мэргэшлийг харгалзан) үүрэг гүйцэтгүүлэх нь оновчтой гэж дүгнэн үзлээ.

Ашигласан материал

- Монгол Улсын хууль болон олон улсын гэрээ, конвенц
1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. УБ., 2011. №8.
 2. Зөрчлийн тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. УБ., 2017. №24.
 3. Монгол Улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. УБ., 1992. №1.
 4. Төрийн албаны тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. УБ., 2018. №1.
 5. Хөдөлмөрийн тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. УБ., 2021. №31.
 6. Цагдаагийн албаны тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. УБ., 2017. №8.
 7. Эрүүгийн хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. УБ., 2016. №7.
 8. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. УБ., 2017. №23.
- Тогтоол, тушаал, журам, тайлан
9. Монгол Улсын Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам. Зургаа дахь хэвлэл. УБ., 2024.
 10. Хүний эрхийн хорооноос батлан гаргасан ерөнхий санал, зөвлөмжийн эмхэтгэл. УБ., 2004.
 11. Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2024 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн А/194 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралт.
 12. Цагдаагийн байгууллагын зарим ажил, үйлчилгээ, хангалтын жишиг норматив. Цагдаагийн байгууллагын талаар авах зарим арга хэмжээний тухай. Засгийн газрын тогтоол. №153.
- Сурах бичиг, гарын авлага, нэг сэдэвт бүтээл
13. Амарсайхан Ц., Амарсанаа Ж. Процессын эрх зүй: онол, туршлага. УБ., 2013.
 14. Мөнхзул Н. Төрийн тусгай албан хаагчид хүлээлгэх сахилгын хариуцлага. Нэг сэдэвт бүтээл. УБ., 2024.
 15. Цэвэл Я. Монгол хэлний товч тайлбар толь. Нэмж дэлгэрүүлсэн дөрөвдүгээр хэвлэл. УБ., 2021.
 16. Чимэд. Б. Төр, нам, эрх зүйн шинэтгэлийн эгзэгтэй асуудал. Хоёрдугаар дэвтэр. УБ., 2008.
- Судалгааны ажил
17. Монгол Улсын жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ. Үнэлгээний тайлан. УБ., 2021.

18. Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тайлан. Уб., 2022.
19. Нээлттэй нийгэм форум. Дотоод хэргийн их сургууль. Цагдаагийн алба хаагчдын ажил дүгнэх үзүүлэлт хүний эрхийн зарчимд нийцэж буй эсэх. Судалгааны тайлан. Уб., 2020.
20. Хөгжлийн замнал сан. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах Монгол Улсын хуулийг хэрэгжүүлэх Засгийн газрын дунд хугацааны стратеги, төлөвлөгөө (2013-2016)-ний хэрэгжилтийн үр дүнгийн үнэлгээний тайлан. Уб., 2016.
21. Хүний эрхийн Үндэсний Комисс. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэл. Уб., 2017.
22. Хүний эрхийн Үндэсний Комисс. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 13 дахь илтгэл. Уб., 2014.
23. Хүний эрхийн Үндэсний Комисс. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл. Уб., 2023.
24. комисс, Х. э. (2014 оны 12 26). Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 13 дахь илтгэл. *Хүний эрхийн үндэсний комисс Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл*, хууд. 100.
25. комисс, Х. э. (2023 оны 5 2). Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл. *Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл*, хууд. 66.
26. УИХ, У. И. (2017 оны 2 9). *Цагдаагийн албаны тухай хууль. 11 дүгээр зүйл. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем*: <https://legalinfo.mn/mn/detail/12469&menuid=74>-ээс Гаргасан
27. УИХ, У. И. (2017 оны 5 18). *Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. 1.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем*: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=12694>-ээс Гаргасан